




МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ



ЖИЛИЙН ТАЙЛАН

Хөдөө аж ахуйн бирж



АГУУЛГА

КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

АЛБАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧИГ ҮҮРЭГ

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГҮЙ

2013 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

АРИЛЖАА

НООЛУУРЫН АРИЛЖАА

ХОНИНЫ НООСНЫ АРИЛЖАА

ТЭМЭЭНИЙ НООСНЫ АРИЛЖАА

ТОСНЫ УРГАМЛЫН АРИЛЖАА

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

ГИШҮҮД

БИРЖИЙН БАЙНГЫН ГИШҮҮН ОРОЛЦОГЧ БРОКЕРЫН КОМПАНИУД



Монгол улсын Засгийн газрын 2013 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн хороо эрх хэмжээнийхээ хүрээнд 2013 оны 02 дугаар сарын 28-ний өдөр 45 тоот тогтоол гаргаж, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийг үүсгэн байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагыг томилсон. Мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах, компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлагын тогтолцоог сайжруулах, удирдлагын бүтцийг оновчтой зохион байгуулах, компанийн засаглалыг боловсронгуй болгох зэрэг ажлын хүрээнд компанийн тухай хууль болон дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж хараат бус гишүүдийг сонгон шалгаруулж томиллоо.



Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд

Ц.Баярмаа	ТҮЗ-ийн дарга
Н.Ганибал	ТҮЗ-ийн гишүүн
Э.Эрдэнэсүрэн	ТҮЗ-ийн гишүүн
Л.Баатарчулуун	ТҮЗ-ийн гишүүн
Э.Хэрлэн	ТҮЗ-ийн гишүүн
Э.Батбаяр	ТҮЗ-ийн гишүүн
О.Отгонбаяр	ТҮЗ-ийн хараат бус гишүүн
С.Оюунгэрэл	ТҮЗ-ийн хараат бус гишүүн
Н.Наранцэцэг	ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга

Компанийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан

Ж.Эрдэнэбат	Гүйцэтгэх захирал
Ц.Хүрэлбаатар	Арилжааны албаны захирал
Ч.Чимэгбаатар	Гишүүнчлэлийн албаны захирал
Д.Батжаргал	Захиргааны албаны захирал
Б.Буянхишиг	Клиринг, төлбөр тооцооны албаны захирал
Ж.Эрдэнэболд	Логистик, барааны албаны захирал
Д.Эрдэнэбат	Мэдээллийн технологийн албаны захирал
П.Дашдорж	Хяналт, мониторингийн албаны захирал



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Ц.Баярмаа

ҮХААЯ-ны Хөнгөн
үйлдвэрийн бодлогын
хэрэгжилтийг
зохицуулах газрын
дарга



О.Отгонбаяр

Хантайшир Дээд
сургуулийн захирал



С.Оюунгэрэл

Голден пейж аудит
ХХК-ийн аудитор



Л.Баатарчулуун

ТӨХ-ны Бүтцийн
еөрчлөлтийн бодлогыг
хэрэгжүүлэх газрын
мэргэжилтэн



Э.Хэрлэн

СЗХ-ны дэд дарга



Э.Батбаяр

Сангийн яамны
Төсвийн бодлого,
төлөвлөлтийн газрын
Орлогын хэлтсийн
дарга



Э.Эрдэнэсүрэн

Эдийн засгийн
хөгжлийн яамны
Хуулийн хэлтсийн
дарга



Н.Ганибал

ҮХААЯ-ны Мал аж
ахуйн бодлогын
хэрэгжилтийг
зохицуулах газрын
дарга



АЛБАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧИГ ҮҮРЭГ

ЗАХИРГААНЫ АЛБА

Биржийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой хангах чиг үүргийн хүрээнд санхүү, аж ахуй, хүний нөөц, хууль эрх зүй, мэдээлэл гадаад дотоод харилцаа холбоо, сургалт, бичиг хэрэг, архивын асуудлыг эрхэлнэ.

АРИЛЖААНЫ АЛБА

Арилжааг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд арилжааг хянах, арилжаатай холбоотой тайлан мэдээ гаргах, арилжигдсан бүтээгдэхүүнд биржийн барааны тодорхойлолт олгох ажлыг хариуцан эрхэлнэ.

КЛИРИНГ, ТӨЛБӨР ТООЦООНЫ АЛБА

Арилжааны дараах үеийн клирингийн үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөн төлбөр тооцоог банкны системээр дамжуулан гүйцэтгэх, төлбөр тооцооны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллах чиг үүрэгтэй.

ГИШҮҮНЧЛЭЛИЙН АЛБА

Гишүүнчлэлийн алба нь фьючерсийн арилжааны бэлтгэл ажлыг хангах зорилгоор гишүүнчлэлийн эрхзүй, зохион байгуулалтын орчинг улам тодорхой, боловсронгуй болгох; Бирж болон биржийн гишүүний хоорондын харилцааг бүрэн онлайн хэлбэрт шилжүүлэх; гишүүдийг онол-практикийн цуврал сургалт, семинарт тодорхой үе шаттай хамруулах; Биржийн гишүүнчлэлд хамрагдах чадамж, боломжийг бүс нутаг тус бүрээр тодорхойлох; Биржийн гишүүн болон болохоор хандагчид тавих нөхцөл шаардлагын биелэлт, байдалд хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлнэ.



ЛОГИСТИК, БАРААНЫ АЛБА

Биржээр арилжих бараа, түүхий эдийн агуулах, тээврийн байгууллагад итгэмжлэл олгох, үйл ажиллагаанд холбогдох журмыг мөрдүүлэх, хяналт тавих, биржээр арилжих бараа, түүхий эдийн судалгаа хийх, тодорхойлолт боловсруулах, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд хоршоо байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, чиг үүрэгтэй.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБА

Биржийн арилжаа, клиринг төлбөр тооцоо, логистик, гишүүнчлэл болон хяналтын цахим системийг хөгжүүлэх, арилжаа, төлбөр тооцоог онлайн хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн технологитой холбоотой бусад асуудлыг хариуцаж ажиллана.

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН АЛБА

Үйл ажиллагааны дотоод хяналт шалгалт хийх, мэдээ мэдээлэл бэлтгэх, удирдлагыг мэдээллээр хангах, салбарын хууль тогтоомж, шийдвэр, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах, хүргүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, зах зээлийн оролцогчдыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийж ажилладаг.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГҮЙ

2013

Орлогын тайлан	
Борлуулалтын орлого (цэвэр)	1,445,214,867
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	393,803,777
Татварын дараах ашиг (алдагдал)	348,215,355
Баланс	
Нийт хөрөнгийн дүн	1,513,490,020
Үүнээс: Үндсэн хөрөнгө	1,273,958,579
Спот зах зээлийн үзүүлэлтүүд	
Ноолуурын арилжааны дүн	385,204,868,000
Ноосны арилжааны дүн	6,542,080,000
Тосны ургамлын арилжааны дүн	11,853,700,000
Компанийн үзүүлэлтүүд	
Байнгын гишүүдийн тоо	27
Харилцагчийн тоо	375
Ажилчдын тоо	29
1 ажилтанд ногдох борлуулалтын орлого	49,834,995

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлж, ҮХААЯ-наас өгсөн чиглэл зөвлөмжийн дагуу туршилтын арилжааг 2013 оны 04 сарын 05-ны өдрөөс эхлэн явуулж байна.


Одоогийн байдлаар нийт 29 брокерын компани биржийн гишүүнчлэлийн шалгуурыг хангаж, СЗХ-ноос батлан гаргасан тусгай зөвшөөрөл авч, биржийн түр журмын дагуу арилжаанд оролцож байна. Биржийн арилжаа цахилгааны хязгаарлалтаас шалтгаалж 3 өдөр, арилжааны захиалга ирүүлээгүй шалтгаанаар 56 өдөр тус тус тасалдсан.



ҮХААЯ-ны дэд сайд,
Хөдөө аж ахуйн биржийн арилжааны нээлтийн үеэр

Энэ онд бирж нийт 131 удаагийн арилжааг зохион байгуулаад байгаа бөгөөд биржийн арилжаагаар нийт 6 төрлийн ноолуур, 7 төрлийн тэмээний ноос, 4 төрлийн хонины ноос, 2 төрлийн тосны ургамал тус тус арилжигдаж, арилжааны дүн 400 тэрбум төгрөг даваад байна.





Зорилтот түвшингийн хүрээнд :

- 2013 онд улсын хэмжээнд нийт 5500 тонн түүхий ноолуур, 22000 тонн ноос, 350000 тонн улаан буудай бэлтгэх урьдчилсан статистик тооцоо гарсанд үндэслэн зах зээлд нийлүүлэгдэх нийт түүхий ноолуурын 55 орчим хувийг биржээр арилжихаар төлөвлөж үнийн хувьд ноолуурын чанар, гарцаас хамааран нэг килограмм нь 50,000-65,000 төгрөгийн хооронд байхаар тооцож байсан бол 2013 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр бирж нийт 385.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 6382 тонн ноолуур арилжиж, 1 кг ноолуурын үнэ 57000 - 82000 төгрөгийн хооронд хэлбэлзэж зорилтоо давуулан биелүүлжээ.

- Ноосны 60 хувь буюу 13000 тонн хонины ноос, 1 кг нь зах зээлийн үнээр буюу дунджаар 500 төгрөгөөр арилжигдахаар төлөвлөснөөс 2052 тонн тэмээний болон хонины ноосыг 1 кг нь 1200 - 6000 төгрөгөөр арилжиж 6.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн.

- Хүнсний улаан буудайн 35 орчим хувь нь биржээр арилжигдах тооцоо хийсэн боловч тодорхой шалтгаануудын улмаас улаан буудай арилжигдаагүй.

- Хөдөө аж ахуйн биржийн тухай хуулийн 4.5-д заасныг үндэслэн Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын батлан гаргасан тушаалын дагуу 2013 оны 12 дугаар сараас эхлэн тосны ургамал арилжиж эхэлсэн бөгөөд 2 төрлийн нийт 14912 тонн тосны ургамлыг 12 тэрбум төгрөгөөр арилжаад байна.



Түүнчлэн “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2013 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- 🔗 **Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай холбоотой журмуудыг боловсруулж, батлав.**

“ХАА-н гаралтай бараа түүхий эдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн биржийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах, биржийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах зорилгоор Арилжааны түр журам, Гишүүнчлэлийн түр журам, Итгэмжлэгдсэн агуулахын түр журам, Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн түр журам, Клиринг төлбөр тооцооны журмуудыг тус тус боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

- 🔗 **Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн тодорхойлолтыг боловсруулав.**

“ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 4.5-д заасны дагуу батлагдсан Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтанд орсон дараах бараа, түүхий эдийн тодорхойлолтыг боловсрууллаа. Үүнд:

1. Ямааны ноолуур
2. Хонины ноос
3. Тэмээний ноос
4. Бодын хөөвөр
5. Хүнсний буудай
6. Тосны ургамал /рапс/
7. Мал

- 🔗 **Захиалга бүртгэлийн систем, Арилжааны систем, Клирингийн системийг бэлтгэж, ашиглаж эхэллээ.**

2013 онд Хөдөө аж ахуйн бирж нь спот арилжааг зохион байгуулах, түүний хэвийн тасралтгүй явагдах нөхцөлийг хангах зорилгоор Захиалга бүртгэлийн систем, Арилжааны систем, Клирингийн системийг тус тус амжилттай бэлтгэн, спот арилжааг зохион байгуулахад



ашиглаж байна. Түүнчлэн агуулахад байгаа бараа, түүхий эдийг бүртгэх зорилгоор агуулахын бүртгэлийн программыг бэлтгэн, хөгжүүлж байна. Түүнчлэн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, орон нутгаас арилжаанд шууд оролцох боломжийг хангах зорилгоор биржийн арилжааг онлайн хэлбэрээр зохион байгуулах ажлын хүрээнд арилжааны нэгдсэн системийг онлайн хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлыг хийж дуусгаад байна.

🔗 Хамтран ажиллах санамж бичгүүд байгууллаа.

“ХАА-н гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн 4,6 дахь заалтын дагуу экспортод гаргах бараа түүхий эдэд биржээр арилжаалсан тухай барааны тодорхойлолтыг олгож эхэлсэн. Улаанбаатар хот дахь гаалийн байгуулага биржийн хооронд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор санамж бичиг байгуулсан. Мөн хэрэглэгч, үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг олон шат дамжлагаар дамжсан элдэв нэмэгдэл өртгөөр бус, илүү хямд өртгөөр, чанартай бэлтгэхэд хяналт тавих зорилгоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай Хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Экспортод гаргах гэж байгаа биржээр арилжаалсан болон арилжих бараа бүтээгдэхүүнд дүгнэлт гаргуулах зорилгоор лабораторийн шинжилгээ хийлгэж ноос ноолуурын чанарыг бодиттой үнэн зөв тогтоох талаар ХААИС-ийн Биологийн нөөцийн менежментийн сургууль болон ШҮТИС-ийн Нэхмэлийн хүрээлэнтэй Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

🔗 “Жишиг хоршоо” байгуулах төсөл боловсруулж байна.

ҮХААЯ, ЭЗХЯ-наас Баянхонгор аймгийн 2 суманд хэрэгжүүлж байгаа “Жишиг сум” төслийн хүрээнд Бууцагаан, Баянлиг сумдад томилолтоор ажиллаж судалгаа хийсэн бөгөөд судалгаанд үндэслэн “Жишиг хоршоо” байгуулах төслийг боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах ажлуудыг эхлүүлээд байна.



🕒 Агуулахуудад итгэмжлэл олгож, хяналт тавьж ажиллав.

Хөдөө аж ахуйн биржийн “Итгэмжлэгдсэн агуулахын үйл



ажиллагааны түр журам”-д заасны дагуу 2013 оны 4 дүгээр сараас эхлэн 3 сарын хугацаатайгаар шаардлага хангасан агуулахуудад түр итгэмжлэл олгосон бөгөөд одоогоор итгэмжлэлийн хугацаа дууссан агуулахуудын үйл ажиллагааг дахин шалгаж, итгэмжлэлийг 1 жилийн хугацаагаар сунгаж байна. Нийт 28 агуулахад итгэмжлэл олгон, бүртгэснээс Улаанбаатарт 8, орон нутагт 20 агуулах бүртгэлтэй

байна.

Улаанбаатарт байрлах шинээр итгэмжлэл хүссэн агуулахыг үзэж танилцах, итгэмжлэл олгосон агуулахуудын үйл ажиллагааг шалгах зорилгоор 2013 оны 06-р сарын 10-12-ны хооронд нийт 4 удаагийн шалгалт хийх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.

Агуулахад итгэмжлэл олгох ажлын хүрээнд 2013 оны 10-р сарын 22-ны өдөр батлагдсан “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирлын А/60 тоот тушаалын дагуу томилогдсон ажлын хэсэг 2013.10.23-26-ны өдрүүдэд 3 хоногийн турш Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Хөтөл, Булган аймаг дахь ТЭДС-ийн үйл ажиллагаатай танилцлаа. Түүнчлэн 2013.10.27-ноос 2013.11.01-ны хооронд Баянхонгор, Өвөрхангай аймагт ажиллах томилолтын хүрээнд Өвөрхангай аймгийн Хархорин сумын ТЭДС-ийн үйл ажиллагаатай мөн танилцсан бөгөөд нийт ТЭДС-ийн 5 агуулахад захиалга бүртгэлийн программ суулган, агуулахын итгэмжлэл олгов.

🕒 Тээврийн компаний үйл ажиллагаатай танилцан итгэмжлэл олгов.

Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн түр журмын дагуу "ED logistic" ХХК, "Тав" ХК-аас ирүүлсэн материалтай танилаж тэдгээр байгууллагын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үзэж шалгах ажлыг газар дээр явуулж итгэмжлэлийн шалгуурыг хангасан гэж үзсэн тул Захирлуудын зөвлөлд танилцуулан тус компаниудад итгэмжлэл олгосон.



🔍 Судалгааны ажлууд

“ХАА-н биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн, эдийн засгийн шинэ харилцаа үүсэн бий болсонтой холбогдуулж энэхүү зах зээлийн талаарх мэдээллийг нарийвчлан гаргах, бараа түүхий эдийн бирж дээр арилжигдах шинэ бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлтэй холбоотой судалгааг хийхэд компанийн зүгээс анхаарч 2013 онд дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- Фьючерс болон бусад төрлийн бараа түүхий эдэд суурилсан хугацаат гэрээнүүд, монголд нэвтрүүлж болох фьючерс гэрээний төрлүүд, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөө, бараа түүхий эдэд суурилсан хугацаат гэрээнүүд нэвтрүүлэхэд хийх шаардлагатай алхмуудыг тодорхойлох зорилгоор гэрээ буюу дериватив бүтээгдэхүүний талаар судалгаа
- Макро болон микро Эдийн засгийн орчны судалгаа. Өмнөх жилүүдийн ноолуурын үнэ, экспортын хэмжээ ба Монголын ноолуурын гол импортлогч орнуудын судалгаа, ноолуур, тэмээний ноос, хонины ноос, улаан буудай, мал, махны статистик тоон судалгаа
- Олон улсын таварын биржүүдийн талаарх судалгаа
- Биржийн үйл ажиллагаа болон зах зээлийн эрсдэлийг тодорхойлох, судлах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрсдэлийн судалгааны багийн хийсэн судалгаанууд
- Хугацаат гэрээний арилжаа, онлайн арилжаатай холбоотой судалгаа, хугацаат гэрээний арилжаа зохион байгуулахтай холбогдсон судалгаа, кодлолт
- Үйл ажиллагааны 2-р шатанд Гишүүнчлэлийн төрөл ямар байх тухай биржийн гишүүнчлэлтэй холбоогдсон судалгаа
- Биржийн 2014-2016 оны нийгэм, эдийн засгийн судалгаа

🔍 Эрсдэлийн удирдлагын баг байгуулан ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон эрсдэлийн удирдлагын багийг Хяналт, мониторингийн албанаас ахлан ажиллаж байгаа бөгөөд эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг батлуулж түүний дагуу Биржийн үйл ажиллагаанд үүсч болох эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж холбогдох арга хэмжээнүүдийг авч ажилласан.



- ☑ Брокерын компаниудтай гэрээ байгуулж, биржийн гишүүнчлэл олгов.

2013 онд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 27 брокерын компанитай гэрээ байгуулж, арилжаанд оролцох эрх олгосон.

- ☑ Биржийн хяналт, мониторингийн үйл ажиллагаа.

ХАА-н Бирж нь хууль тогтоомжийн дагуу, өөрийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахад Биржийн хяналт, мониторингийн алба тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Биржийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын биелэлтэнд хяналт тавих, Биржээр арилжигдсэн бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт олгох явцад хяналт тавих, байгууллагын удирдлага, албан тушаалтныг шаардлагатай мэдээ мэдээлэл, дүгнэлт зөвлөмжөөр цаг тухайд нь хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. Тухайлбал, Авлигын эсрэг хуульд заасны дагуу Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулан, түүний дагуу биелэлтийг хангах, сургалт мэдээллээр ажилтнуудыг хангах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



2013 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



- 02-р сарын 28 ~ Төрийн өмчийн хорооны 45 тоот тогтоолоор Хөдөө аж ахуйн бирж байгуулагдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг томилов.



- 04-р сарын 05 ~ Хөдөө аж ахуйн биржийн туршилтын арилжаа албан ёсоор эхлэв.



- 06-р сарын 05 ~ ҮХАА-н сайд Х.Баттулга Арилжааны танхимд хүрэлцэн ирж, үг хэлж, цан цохин арилжааг нээв.

1-р сар

2-р сар

3-р сар

4-р сар

5-р сар

6-р сар

- 03-р сарын 23 ~ Хөдөө аж ахуйн биржийн туршилтын арилжааны түр журмуудын эмхэтгэлийг ТУЗ-ийн хурлаар батлав.

- 05-р сарын 06 ~ ХААБ-ийн анхны арилжаа эхлээд 1 сар болж байгааг дүгнэх, 2 дахь сарын үйл ажиллагааг албан ёсоор нээх ёслол болов.





- 08-р сарын 20 ~ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурав.

- 10-р сарын 25 ~ Улаанбаатар хот дахь Гаалийн газартай 2013-2014 онд хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурлаа.



- 12-р сарын 26 ~ Биржийн арилжааны дүн 400 тэрбум төгрөгийг давлаа.

7-р сар

8-р сар

9-р сар

10-р сар

11-р сар

12-р сар

- 07-р сарын ~



- 09-р сарын 30 ~ Хөдөө аж ахуйн биржийн 100 дахь арилжаа явагдлаа.

- 12-р сарын 31 ~ Биологийн нөөцийн менежментийн сургууль, Нэхмэлийн хүрээлэнтэй хамтран ажиллах Санамж бичиг байгуулан, гарын үсэг зурав.



БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

403,600,648,000


“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2013 онд нийт 131 удаагийн арилжаа зохион байгуулж:

- ✔ 6382 тонн ноолуур;
- ✔ 1005 тонн хонины ноос;
- ✔ 1048 тонн тэмээний ноос;
- ✔ 14912 тонн тосны ургамлыг 403,600,648,000 төгрөгөөр арилжлаа.

Тайлант хугацаанд арилжааны өдрийн дундаж дүн 3.1 орчим тэрбум төгрөг байсан бол оны хамгийн өндөр дүнтэй арилжаа 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр 13.1 тэрбум төгрөг; хамгийн бага дүнтэй арилжаа 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдөр 23.9 сая төгрөг байлаа.

3.1 тэрбум


Энэ онд бараа түүхий эдийн дундаж үнийн хувьд ноолуур 1 богц нь 603575 төгрөг, хонины ноос 1 богц нь 147476 төгрөг, тэмээний ноос 1 богц нь 48277 төгрөг, тосны ургамал 1 богц нь 794910 төгрөг байв.



Хөдөө аж ахуйн биржийн түүхий, угаасан, самнасан 11 төрлийн ноолуур, 19 төрлийн тэмээний ноос, 19 төрлийн хонины ноос, 2 төрлийн тосны ургамал арилжигдах боломжтойгоос 2013 онд 6 төрлийн ноолуур, 7 төрлийн тэмээний ноос, 4 төрлийн хонины ноос, 2 төрлийн тосны ургамал тус тус арилжигдсан байна.



Өдрийн арилжааны дүн, тэрбум төгрөгөөр




Биржийн арилжааны дүн 4 болон 5 дугаар саруудад хамгийн өндөр дүнтэй байсан бөгөөд ноолуурын гарц багассантай холбоотойгоор 7,8 сараас арилжааны дүн буурсан ч 2 төрлийн ноос, тосны ургамал арилжигдаж эхэлснээс хойш өдрийн арилжааны дүн дахин нэмэгдэж байна.

Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн хэмжээ, тонн

Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн хэмжээг авч үзвэл ноолуур зорилтот хэмжээнээс давж 6382 тонн арилжигдсан бол хамгийн сүүлд арилжигдаж эхэлсэн

боловч тосны ургамлын арилжаа харьцангуй идэвхтэй явагдаж нийт 14 тонн тосны ургамал биржээр арилжигдаад байна.



Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн үнийн дүн



Арилжигдсан бараа, түүхий эдийн үнийн дүнгийн хувьд нийт биржийн арилжаанд эзлэх үнийн дүнгээр ноолуурын арилжаа хамгийн өндөр бөгөөд зөвхөн дангаар нийт арилжааны 95 орчим хувийг бүрдүүлжээ.



НООЛУУРЫН АРИЛЖАА


Хөдөө аж ахуйн биржээр 2013 оны 04 сараас ямааны ноолуур арилжигдаж эхэлсэн бөгөөд бараан, цайвар, цагаан, ангилаагүй гэсэн 4 төрлийн 6382.06 тонн ноолуур 385.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр арилжигдлаа. Ноолуурын арилжааны эхэн үед зөвхөн түүхий ноолуур арилжигдаж байсан бол 2013 оны 12 сараас угаасан ноолуур арилжигдаж эхэлсэн. Ангилаагүй буюу дээрх 3 өнгийн холимог ноолуур биржээр хамгийн их хэмжээтэй буюу 2770 тн арилжигдаж, нийт үнийн дүн 160 тэрбум орчим төгрөг болжээ. Ноолуурын арилжаа нь биржийн нийт арилжаанд эзлэх хувиар нэлээд өндөр, ач холбогдол бүхий бараа бөгөөд биржийн нийт арилжааны 95 хувийг дангаараа бүрдүүлсэн.

Ноолуур /1 боги=10 кг/

№	Барааны төрөл	Жигнэсэн дундаж үнэ /төг-кг/	Хэмжээ /тонн/	Нийт үнэ /төг/
1	Цайвар, Түүхий	61,661	2016.18	124,318,720,000
2	Цагаан, Түүхий	67,280	186.89	12,573,880,000
3	Бараан, Түүхий	62,080	1361.67	84,533,037,000
4	Ангилаагүй, Түүхий	57,723	2769.72	159,876,031,000
5	Бараан, Угаасан	82,000	14.28	1,170,960,000
6	Цайвар, Угаасан	82,000	33.32	2,732,240,000
Нийт			6382.06	385,204,868,000

Ноолуурын үнийн хувьд өнгөрсөн жилүүдийг бодвол харьцангуй тогтвортой байсан бөгөөд 1 кг ноолуур дунджаар 68,800 төгрөг орчим байлаа. Хөдөө аж ахуйн бирж байгуулагдахаас өмнөх жилүүдэд буюу 2011 онд 1 кг ноолуурын дундаж үнэ Улаанбаатарт 51,500 төгрөг, 2012 онд 47,250 төгрөг байсан байна.

Ноолуурын дундаж үнэ /төг, богиоор/



ХОНИНЫ НООСНЫ АРИЛЖАА

Хөдөө аж ахуйн биржээр 2013 оны 06 сараас хонины ноос арилжигдаж эхэлсэн бөгөөд нийт 1005.4 тонн хонины ноос 1.48 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр арилжигдлаа. Хонины ноосны арилжааны хувьд түүхий, угаасан, самнасан ноос арилжигдсан бөгөөд хонины үргэлж цагаан ноос хамгийн их хэмжээтэй арилжигдан, үнийн дүн нь 1.27 тэрбум төгрөг болсон байна.

<u>Хонины ноос /1 богц=100 кг/</u>				
№	Барааны төрөл	Жигнэсэн дундаж үнэ /төг-кг/	Хэмжээ /тонн/	Нийт үнэ /төг/
1	Үргэлж ноос (цагаан, угаасан)	2,588	185.2	474,480,000
2	Үргэлж ноос (цагаан, түүхий)	1,200	629.0	754,800,000
3	Үргэлж ноос (цагаан, самнасан)	2,700	16.0	43,200,000
4	Доод ангийн ноос (угаасан)	1,200	175.2	210,240,000
Нийт			1005.4	1,482,720,000

Хонины ноосны үнийн хувьд 2013 онд биржээр арилжигдсан 1 кг хонины ноосны дундаж үнэ 1,900 төгрөг байсан бол өнгөрсөн жилүүдэд тус тус 2011 онд 520 төгрөг, 2012 онд 670 төгрөг байжээ. 2013 онд хонины ноос арилжигдсан хамгийн өндөр үнэ 270,000 төг /1 богц/ буюу 1 кг нь 2700 төгрөгийн үнэтэйгээр арилжигдлаа.

Хонины ноосны дундаж үнэ /төг, богцоор/



ТЭМЭЭНИЙ НООСНЫ АРИЛЖАА


Хөдөө аж ахуйн биржээр 2013 оны 05 сараас эхлэн тэмээний ноос арилжигдаж эхэлсэн бөгөөд нийт 1047.99 тонн тэмээний ноос 5.06 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр арилжигдлаа. Тэмээний ноосны арилжигдсан хэмжээг авч үзвэл цайвар, түүхий ноос хамгийн их хэмжээтэй арилжигдсан байна.

Тэмээний ноос /1 богц=10 кг/

№	Барааны төрөл	Жигнэсэн дундаж үнэ /төг-кг/	Хэмжээ /тонн/	Нийт үнэ /төг/
1	Их биеийн ноос (цайвар, угаасан)	6,000	26.5	159,000,000
2	Их биеийн ноос (цайвар, түүхий)	4,778	328.81	1,507,850,000
3	Их биеийн ноос (бараан, угаасан)	5,267	165.46	862,350,000
4	Их биеийн ноос (бараан, түүхий)	4,556	298.25	1,298,625,000
5	Зогдрын ноос (цайвар, түүхий)	4,676	13.6	63,600,000
6	Зогдрын ноос (бараан, түүхий)	5,769	140.73	761,115,000
7	Зогдрын ноос (бараан, угаасан)	5,504	74.64	406,820,000
Нийт			1047.99	5,059,360,000

Тэмээний ноосны үнийн хувьд 1 кг тэмээний ноос дунджаар 5,200 төгрөг орчим байлаа.

Тэмээний ноосны дундаж үнэ /төг, богцоор/



ТОСНЫ УРГАМЛЫН АРИЛЖАА


Хөдөө аж ахуйн биржээр 2013 оны 12 сараас эхлэн хар, шар гэсэн 2 төрлийн тосны ургамал арилжигдаж эхэлсэн бөгөөд нийт 14,912 тонн тосны ургамал 11.85 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр арилжигджээ. Тосны ургамал нь бусад 3 бараатай харьцуулахад харьцангуй сүүлд буюу 12 сарын 02-ны өдрөөс эхлэн арилжигдаж эхэлсэн ч багагүй хэмжээний тосны ургамал биржээр арилжигдаад байна.

Тосны ургамал /1 богц=1 тонн/

№	Барааны төрөл	Жигнэсэн дундаж үнэ /төг-тн/	Хэмжээ /тонн/	Нийт үнэ /төг/
1	Хар	850,000	5,755	4,891,750,000
2	Шар	760,287	9,157	6,961,950,000
	Нийт		14,912	11,853,700,000

Тосны ургамлын үнийн хувьд бусад бараатай харьцуулахад харьцангуй тогтвортой байсан бөгөөд 1 тонн хар тосны ургамал дунджаар 850,000 төгрөг, 1 тонн шар тосны ургамал 760,000 төгрөг байлаа.

Тосны ургамлын дундаж үнэ /төг, богцоор/



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,000	176,834,282
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		32,868,072
1.1.4	Бусад авлага		2,994,441
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал		7,584,203
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		19,250,443
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,000	239,531,441
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		437,034,607
1.2.2	Биет бус хөрөнгө		836,923,972
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,273,958,579
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,513,490,020
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		900,601
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		184,661
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах хөрөнгө		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,085,262
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		4,479,403
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		4,479,403



2.2	Өр төлбөрийн нийт дүн		5,564,665
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	10,000	10,000
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		1,159,700,000
2.3.9	Хуримтлагдсан ашиг		348,215,355
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,000	1,507,925,355
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	10,000	1,513,490,020



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,445,214,867
2	Борлуулалтын өртөг	
3	Нийт ашиг (алдагдал)	1,445,214,867
4	Түрээсийн орлого	
5	Хүүний орлого	27,777,773
6	Ногдол ашгийн орлого	
7	Эрхийн шимтгэлийн орлого	
8	Бусад орлого	
9	Борлуулалт, маркетингийн зардал	21,043,000
10	Ерөнхий ба удирдлагын зардал	995,703,972
11	Санхүүгийн зардал	
12	Бусад зардал	62,080,441
13	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(361,451)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	
17	Бусад ашиг (алдагдал)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	393,803,777
19	Орлогын татварын зардал	45,588,422
20	Татварын дараах ашиг (алдагдал)	348,215,355
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	348,215,355
23	Бусад дэлгэрэнгүй орлого Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү Бусад олз (гарз)	
24	Орлогын нийт дүн	
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн (+) Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө Буцаан авсан албан татвар Татаас, санхүүжилтийн орлого Бусад мөнгөн орлого	1,445,214,867 1,445,214,867
1.2	Мөнгөн зарлагын дүн (-) Ажиллагчдад төлсөн Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн Бараа материал худалдан авахад төлсөн Ашиглалтын зардалд төлсөн Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн Хүүний төлбөрт төлсөн Татварын байгууллагад төлсөн Даатгалын төлбөрт төлсөн Бусад мөнгөн зарлага	1,108,594,290 538,430,937 102,577,316 28,316,292 5,764,270 131,289,230 104,450 302,111,795
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	336,620,577
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
2.1	Мөнгөн орлогын дүн (+) Үндсэн хөрөнгө борлуулсны орлого Бит бус хөрөнгө борлуулсны орлого Хөрөнгө оруулалт борлуулсны орлого Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт Хүлээн авсан хүүний орлого Хүлээн авсан ногдол ашиг	27,777,773 27,777,773
2.2	Мөнгөн зарлагын дүн (-) Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	169,785,583 168,415,583 1,370,000
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
3.1	Мөнгөн орлогын дүн (+) Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Төрөл бүрийн хандив	49,147,769 49,147,769
3.2	Мөнгөн зарлагын дүн (-) Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	66,936,254 66,574,802



	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	
	Төлсөн ногдол ашиг	361,452
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,788,485)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	176,824,282
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,000
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	176,834,282

САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ /САЯ ТӨГРӨГӨӨР/

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөсөн дүн	Гүйцэтгэлээрх дүн	Төл/Гүйц
1	Нийт төсөвлөсөн орлого	1,038.96	1,472.99	70.5%
1.1	Арилжааны шимтгэлийн орлого	830.96	1,270.78	65.4%
1.2	Элсэлтийн хураамжийн орлого	208.00	169.0	123.1%
1.3	Сүүдлын төлбөрийн орлого	-	-	-
1.4	Бусад орлого	-	33.21	-
2	Нийт төсөвлөсөн зардал	1,530.49	1,079.19	141.8%
2.1	Цалин хөлс, ЭМНДШ-ийн зардал	618.71	531.49	116.4%
2.2	Удирдлагын зардал	113.00	112.80	100.2%
2.3	ТҮЗ-ийн зардал	52.58	11.87	443.0%
2.4	Түрээсийн зардал	133.90	98.26	136.3%
2.5	Элэгдлийн зардал	96.54	78.03	123.7%
2.6	Бусад зардал	515.76	246.74	209.0%
3	Татварын өмнөх ашиг	(491.53)	393.80	-124.8%
4	Орлогын татвар	-	45.59	-
5	Цэвэр ашиг	(491.53)	348.21	-141.2%
6	Нийт ажиллагсдын тоо	35	29	120.7%
7	Цалингийн сан	648.39	579.29	111.9%
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.47	0.73	201.4%
9	Хөрөнгө оруулалт	864.10	1,349.65	64.0%



БИРЖИЙН БАЙНГЫН ГИШҮҮН ОРОЛЦОГЧ БРОКЕРЫН КОМПАНИУД

№	Компанийн нэр	Орон нутгийн харьяалал	Байнгын гишүүн оролцогчоор элссэн огноо
1	Бадархундага оргил (0001)	Завхан	2013-05-09
2	Хөвчийн тал (0004)	Дорнод	2013-05-02
3	Ханбүргэд хэнтий (0005)	Хэнтий	2013-04-30
4	Ивээлт Инэл (0006)	Улаанбаатар	2013-08-02
5	Сантланс (0007)	Төв	2013-05-08
6	Хаан тэлмэн (0008)	Улаанбаатар	2013-05-02
7	Вүүдсоунд (0009)	Увс	2013-05-27
8	Цэц-Инвест (0010)	Улаанбаатар	2013-04-30
9	Өлгий түүхий эд (0011)	Баян-Өлгий	2013-05-06
10	Саяанхаан (0013)	Булган	2013-04-30
11	Бурхант таван эрдэнэ (0014)	Дархан	2013-06-24
12	Баяр плант (0015)	Улаанбаатар	2013-05-07
13	Батбилгэх (0016)	Дундговь	2013-05-02
14	Гурван цаст гал тамга (0017)	Ховд	2013-05-13
15	МЭТҮ (0018)	Улаанбаатар	2013-05-02
16	Мөрөн таван эрдэнэ (0020)	Хөвсгөл	2013-05-14
17	Засагтхан гарьд (0021)	Завхан	2013-05-01
18	Өвөр таван эрдэнийн шим (0022)	Өвөрхангай	2013-05-01
19	Бурналасан од (0023)	Өмнөговь	2013-07-18
20	Хонгорын таван эрдэнийн хишиг (0025)	Баянхонгор	2013-11-18
21	Танан дээж трейд (0029)	Улаанбаатар	2013-05-06
22	Увс таван эрдэнийн ундарга (0030)	Увс	2013-05-13
23	Алтан шагай импэкс (0031)	Улаанбаатар	2013-05-01
24	Өлгий ундарга (0032)	Баян-Өлгий	2013-05-02
25	Гүүдкомэкс (0033)	Улаанбаатар	2013-05-03
26	Стандарт таваар (0034)	Улаанбаатар	2013-05-23
27	Батсигнач (0035)	Улаанбаатар	2013-08-29





“Хөдөө аж ахуйн бирж” ХХК

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж - 37, GB Plaza

Утас: 7011-8779, 7012-8779, 7012-8775, 7012-8776, 7014-8779

Факс: 7014-8779

www.mce.mn